

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ(Сонгох даалгавар)**Санамж:**

1. Зохиолын хэсгийг анхааралтай уншиж ойлгоорой.
2. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
3. Сонгож авсан үг, өгүүлбэрийг зохиолын хэсгийн утга санаатай холбож ажиглаарай.
4. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой. (Даалгавар бүр 2 оноотой)

Нутаг гүйсэн өнчин унаганы дууль

Эхээсээ хагацсан хөөрхий өнчин ухаа унага гүвээ даваад урамгүйхэн шогшино. Хаашаа яваагаа эс мэдэвч ямар нэг үл үзэгдэх далдын совин билиг түүнийг аль нэг тийш нь хөтөлж явна.

Урт хоногийн тоосонд даруулж, усан борооны хураар угаагдаж, хад чулуунд туурайгаа нухуулж, хавсарга салхинд дэлээ хийсгэн явсаар нарийн хөл нь байргашин, намхан бие нь өндөрсөн өссөөр, өөрийнхөө тоосонд булуулсаар ус унхиалан нууранд тээрсэн адууны дэргэд ирж, хул зүс болгоны өмнө шогшин ойртож, айж хулгасаар дөхөж очих боловч аль нь ч эс хавьтуулан, хулмайн дайрах гэнэ. Ийнхүү адуунаас адуу, айлаас айл, ухаа гүвээнээс ухаа гүвээг дамжин хэжсээр гагцхүү чанх хойд зүгийг барин үл мэдэх нэгэн татах үзүүр лүү явсаар авай.

Хаа хол торойн үзэгдэх хэдэн адууг харан гэнэт үүрсэж, тэгснээ салхин сэвэлзүүлэн хангинатал лимбэдэн янцгаагаад сүүлээ хатган давхив. Юуны учир эс танигдах тэр сүргийн зүг сүүл хатган давхиж, мөнөөх хэдэн адуу нь бусадтай адил эс хажиглав! Өнчин унаганы дотор өвлөөр боловч өн дулаан болбай.

Талын таван уулын сугад бэлчих сүргийнхээ захад очиж явсан адуучин эр хүлгийнхээ амыг шороо манаруулан зог тустал татаад, мөнөөх ухаа унагыг харахдаа тэнгэрээс бууж ирсэн мэт тэр бяцхан амьтныг гайхахын ихээр гайхан, харьд худалдсан ухаагч гүүнээс нь гарсан хонгор азарганы нь үр төл гарцаагүй мөн бололтойд оньсого мэт орчлон ээдэрсэн утас шиг хэрээсэнд төөрөн, нэг бол миний зүүд, эс бол хорвоогийн зүүд гэж нэг бодох авч аандаа байгаль ертөнцийн зөн совин хэмээх нууцлагийн учир начир зүрхэнд нь уусан байвай.

(Г.Мэнд-Ооёо)

1. Өнчин унагыг юу хөтлөн явж байна гэж бичсэн бэ?
 - A. Төрсөн нутагтаа очих хүсэл
 - B. Далдын совин билиг
 - C. Замд тааралдах танил уул ус
 - D. Өөрийн эр зориг
 - E. Адуун сүрэг
2. Яагаад “унаганы дотор өвлөөр боловч өн дулаан болбай” гэж бичсэн бэ?
 - A. Хавсарга салхинд дэлээ хийсгэн явсан учраас
 - B. Эх нутагтаа ирж, ижил олон сүргээ олсон учраас
 - C. Сүргийн зүг сүүл хатган давхисан учраас
 - D. Адуучин эр унагыг харсан учраас
 - E. Унага холын замдаа ядарсан учраас
3. Эхийн өрнөл хэсгийн утгад **хамааралгүй** үгийг сонгоорой.
 - A. Айж хулгасаар...
 - B. Дамжин хэжсээр...
 - C. Лимбэдэн янцгаагаад...
 - D. Урамгүйхэн шогшино...
 - E. Явсаар авай...
4. Дүрслэх хэрэглүүр **илрээгүй** хэсгийг сонгоно уу.
 - A. Оньсого мэт орчлон...
 - B. Ээдэрсэн утас шиг хэрээсэнд...
 - C. Хангинатал лимбэдэн янцгаагаад...
 - D. Хавсарга салхинд дэлээ хийсгэн яваад...
 - E. Тэнгэрээс бууж ирсэн мэт тэр унага...

5. Эхийн сэдвийн тодорхойлоорой.
- A. Эх нутгийн үнэ цэнийн тухай
 - B. Хонгор азарганы үр төлийн тухай
 - C. Байгаль ба амьтны хүйн харьцааны тухай
 - D. Эх орноороо бахархсан бахархлын тухай
 - E. Байгалиараа бахархсан хүний тухай
6. “Хүний хүү нутагтаа суудаг
Хүлгийн хүү төрсөндөө гүйдэг” гэсэн гол санааг илэрхийлсэн хэвшмэл хэлцийн утгыг илэрхийлэх тулгуур өгүүлбэрийг олоорой.
- A. Оньсого мэт орчлон ээдэрсэн утас шиг хэрээсэнд төөрөн, нэг бол миний зүүд, эс бол хорвоогийн зүүд гэж нэг бодох...
 - B. Хул зүс болгоны өмнө шогшин ойртож айж хулгасаар дөхөж очих боловч...
 - C. Эхээсээ хагацсан хөөрхий өнчин ухаа унага гүвээ даваад урамгүйхэн шогшино.
 - D. Адуучин эр хүлгийнхээ амыг шороо манаруулан зог тустал татаад, мөнөөх ухаа унагыг харахдаа тэнгэрээс бууж ирсэн мэт тэр бяцхан амьтныг гайхахын ихээр гайхан...
 - E. Юуны учир эс танигдах тэр сүргийн зүг сүүл хатган давхиж, мөнөөх хэдэн адуу нь бусадтай адил эс хажиглав!
7. “Аандаа байгаль ертөнцийн зөн совин хэмээх нууцлагийн учир начир зүрхэнд нь уусан байвай” гэж бичсэнээр зохиолч юуг хэлэхийг хүссэн бэ?
- A. Орчлон гэдэг оньсого шиг байдаг гэдгийг харуулахыг зорьсон.
 - B. Хүн төдийгүй амьтад ч эх нутагтайгаа далдын гүн холбоотой байдаг юм гэж хэлэхийг хүссэн.
 - C. Унага, хонгор азарганы үр төл гарцаагүй мөн гэж хэлэхийг хүссэн.
 - D. Нутаг гүйсэн өнчин цагаан унаганы тухай өгүүлэхийг зорьсон.
 - E. Талын таван уулын сугад амьдрах адуучин эрийн баяр баяслын тухай өгүүлэхийг зорьсон.
8. “Адуучин эр хүлгийнхээ амыг шороо манаруулан зог тустал татаад, мөнөөх ухаа унагыг харахдаа тэнгэрээс бууж ирсэн мэт тэр бяцхан амьтныг гайхахын ихээр гайхан” гэсэн өгүүлбэрт сэтгэлийн ямар өнгө аяс илэрсэн бэ?
- A. Сэрэмжилсэн өнгө аяс
 - B. Өрөвдсөн өнгө аяс
 - C. Биширсэн өнгө аяс
 - D. Харууссан өнгө аяс
 - E. Санааширсан өнгө аяс
9. Эхийн хэв маягийг зөв тодорхойлсныг олоорой.
- A. Тайлбарласан эх
 - B. Тоочсон эх
 - C. Хүүрнэсэн эх
 - D. Эргэцүүлсэн эх
 - E. Тоочиж, тайлбарласан эх
10. “Сүргийнхээ захад очиж явсан адуучин эр тэр бяцхан амьтныг гайхахын ихээр гайхав” гэсэн өгүүлбэрээс хоёр бүрэлдэхүүнт цөм бүтцийг олоорой.
- A. Сүргийнхээ захад очив.
 - B. Адуучин эр очив.
 - C. Амьтныг гайхав .
 - D. Адуучин эр гайхав.
 - E. Гайхахын ихээр гайхав.
11. Эхийн дүрийн үйлээс үйлчилсэн утгаараа ялгаатай өгүүлбэрийг олоорой.
- A. Урамгүйхэн шогших
 - B. Гүүнээс гарах
 - C. Сүүл хатган давхиж
 - D. Сүргийн захад очих
 - E. Хангинатал янцгаах

12. “Хул зүс болгоны өмнө дөхөж очих **боловч** аль нь ч эс хавьтуулан...” гэсэн өгүүлбэрийн онцолсон холбоосыг тохирох үгээр солин найруулаарай.
 А. улмаар
 В. $\dot{y}\ddot{n}\dot{a}\dot{y}\ddot{e}$
 С. авч
 D. дашрамд
 E. учир
13. “Тэр хаашаа яваагаа эс мэдэвч ямар нэг далдын совинд хөтлүүлнэ” гэсэн өгүүлбэрийг салаалан хувиргасныг олоорой.
 А. Тэр ямар нэг далдын совинд хөтлүүлж хаашаа яваагаа эс мэднэ.
 В. Унага хаачхаа эс мэдэвч ямар нэг далдын зөнбилигт хөтлүүлнэ.
 С. Тэр далдын совинд хөтлүүлнэ.
 D. Тэр хаашаа яваагаа эс мэдэвч ямар нэг далдын совинд хөтлүүлнэ.
 E. Хөөрхий тэр унага хаашаа яваагаа эс мэдэвч нүдэнд үл үзэгдэх далдын зөн совинд хөтлүүлнэ.
14. Найруулгын алдаатай өгүүлбэрийг олоорой.
 А. Бурам амттай боловч буйгаар нь идэж болдоггүй.
 В. Үнэр ялдам агь гангыг эзэгнэнхэн төрлөө, би
 С. Найган ганхах цэцгийг намрын салхи үлээнэ.
 D. Түүний сурдаг байр давчуу боловч сэлүүхэн.
 E. Царайд нь улбар ягаан туяа тодрон, улам ч сайхан болов.
15. “Харьд худалдсан ухаагч гүүнээс нь гарсан хонгор азарганы нь үр төл гарцаагүй мөн” гэсэн өгүүлбэрийн $\dot{o}\dot{a}\dot{d}\dot{y}\ddot{u}\dot{a}\dot{i}$ \dot{u} тодотгол гишүүнийг олоорой.
 А. харьд
 В. хонгор азарганы
 С. ухаагч гүүнээс
 D. үр төл
 E. гарсан
16. “Ижил сүргээ **хайж яваа**энэ бяцхан унагыг битгий үргээгээрэй” гэсэн өгүүлбэрийн онцолсон өгүүлэхүүнийг яаж хувиргавал \dot{o} $\dot{a}\dot{e}\dot{o}\dot{a}\dot{a}\dot{i}$ \dot{u} байц гишүүн өгүүлбэртэй УНӨ болох вэ?
 А. хайж явангаа
 В. $\dot{o}\dot{a}\dot{i}\dot{o}\dot{a}\dot{a}\dot{d}\dot{y}\ddot{u}\dot{a}\dot{a}\dot{o}\dot{e}\dot{d}$
 С. хайж явахад нь
 D. хайж явах
 E. хайж явдаг
17. “Юуны учир эс танигдах сүргийн зүгдавхив” гэсэн өгүүлбэрийн хэв шинжийг тодорхойлоорой.
 А. Харилцан угсарсан нийлмэл өгүүлбэр
 В. Угсарсан нийлмэл өгүүлбэр
 С. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр
 D. Энгийн өгүүлбэр
 E. Холимог нийлмэл өгүүлбэр
18. Дараах холбоо үгийн бүтцийг ажиглаад, цэгийн оронд тохирох үгийг олоорой.
 Гүвээ давах, намхан бие, унаганы дотор, нарийн хөл
 А. хэдэн адуу
 В. унага давхих
 С. учир начир
 D. хураар угаагдах
 E. хонгор азарга
19. “Азарганы үр төл” гэсэн холбоо үгийн харьяалахын тийн ялгалын нөхцөлийн утга аль вэ?
 А. Хамаа харьяаны утга
 В. Орших байр, орон зай заасан утга
 С. Бүхлийн хэсгийг заасан утга
 D. Цаг хугацаа заасан утга
 E. Шинж чанар заасан утга
20. Дараах холбоо үгийг ажиглаад, шууд утгаараа байгаа үгийг олоорой.
 А. хойд зүгийг барих
 В. сэтгэлээ барих
 С. жингээ барих
 D. амаа барих
 E. морио барих
21. Ойролцоо утгатай үгсийг олоорой.
 А. ойж бууж
 В. буурах хөгжих
 С. суудал нүүдэл
 D. эрт урьд
 E. хөгшид хүүхэд

22. Тусах, үүсмэл, өөрөө үйлдэх хэв, энгийн үйлдэх, цагаар төгсгөх нөхцөлтэй үйл үгийг олоорой.
 А. хийсгэн
 В. гайхав
 С. үүрсэж
 D. хэжсээр
 E. хажиглав
23. Үгийн бүтцээр зөв задалсныг олоорой.
 А. сэв+лэ+үүл+0+н
 В. хан+гина+0+тал
 С. нууц+лаг+0+ийн
 D. сүрэг+ийн+ээ
 E. хажиг+л+0+н
24. “Булгийн ус буриглана. Утаа баагиж байна. Тахгүй мориор мөсөн дээр явхад халтирах аюултай. Би эхлээд адуугаа дөхүүлчихээд, буцаад давхиад ирье. Дүү айлын эмээд туслаж байв” гэсэн өгүүлбэрүүдэд зөв бичгийн дүрмийн алдаатай үг хэд байна вэ?
 А. 6
 В. 7
 С. 3
 D. 4
 E. 5
25. Дараах үгээс төрөл биш утгат үгийг олоорой.
 А. хулман
 В. хулмалз
 С. хулмаганах
 D. хулмай
 E. хулмас
26. Үгсийн аймгаар зөв бүлэглэсэн нь аль вэ?
 А. ухаа, урт, хул, нарийн
 В. түүнийг, аль, дэргэд, эс
 С. чанх, дулаан, таван, гэнэт
 D. нэг, учир,ийнхүү, салхи
 E. өн, тэр, өмнө, зүс
27. Гурван үет бүлэг үгс нь аль вэ?
 А. урамгүйхэн, шогшино, яваагаа, үзэгдэх, хоногийн
 В. тоосонд, угаагдаж, туурайгаа, хангинатал
 С. сэвэлзүүлэн, лимбэдэн, сүргийнхээ, худалдсан, бусадтай
 D. өөрийнхөө, булуулсаар, гүвээнээс, хажиглан, бололтойд
 E. хүлгийнхээ, манаруулан, гайхахын, унаганы, нууцлагийн
28. Утга төгс өгүүлбэр бүтээхэд цэгийн оронд аль бүтээврүүд дарааллаараа тохирохвэ?
 “Салхи сэвэлз...,навч...хийсэх... шувууд буцав”
 А. -ээд,-ууд,-д
 В.-ж,-нууд,-ээр
 С.-н,-с,-д,
 D.-сээр,-с,-тэл
 E.-х,-с,-д
29. Үйлээс нэр үг үүсгэх “-лт” дагаврыг найруулгын **хамгийн оновчтой** хэрэглэсэн жишээг олоорой.
 А. Тариа хураалт хийлээ.
 В. Дарга бичилт хийлээ.
 С. Хүүхдэд бүтэлт өгөөд байна.
 D. Багш бодолт хийлээ.
 E. $\tilde{O}i\ddot{a}i\ddot{a} \grave{a}i \ddot{e}e\grave{o} \ddot{a}\ddot{a}e\grave{a}\grave{a}$.
30. Олон тооны дагаврыг зөв хэрэглэснийг олоорой.
 А. олон сурагчдын
 В. хайрцаг шүдэнз
 С. сурагчдын нэрс
 D. хэсэг хүмүүсийн
 E. хүмүүс бид
31. Найруулгын дээд, дунд, доод зэргээр **илрээгүй** бүлэг үгийг олоорой.
 А. явах, гүйх, одох
 В. зооглох, идэх, гудрах
 С. таалал төгсөх, үхэх, мажийх
 D. лагшин, бие, зовлого
 E. айлтгах, хэлэх, чалчих
32. Тодорхойлолтын найруулгад **хамааралгүй** үгийг сонгоорой.
 А. ...оршин суугч мөн болно.
 В. ...үүрэг болгосугай.
 С. ...тэргүүний оюутан болохыг тодорхойлов.
 D. ...сургуульд ажилладаг нь үнэн болохыг тодорхойлов.
 E. ...төгрөгийн цалин авдаг болох нь үнэн болно.

33. “Урьд хожид” гэсэн холбоо үгийн зөв бичсэнийг олоорой.

A B C D E

34. Холбох эгшгийн дүрмээр бичсэн үгийг олоорой.

A B C D E

35. Цэгийн оронд тохирох дагаврыг нөхөж, зүйр цэцэн үг бүтээгээрэй.

A B C D E

36. Монгол бичгээр бичсэн эхийг зөв хөрвүүлснийг олоорой.

	A	B	C	D	E
Алсаас ирэх бэр авдраа бага уудал	Алсаас эрэхээр авдраа уудал	Алсаас ирэхээр авдраа уудал	Алсэзэн ирэхээр авдраа уудал	Алсаас ирэхдээ авдартай угтуул	

37. “Зэ! Хүү минь тийм үү дээ.

Зурмантааны нүхэнд нь
Зургаан салаа байна уу даа
Зулзган чиний чээжинд нь
Зургаан шүлэг байна уу даа
Зэ! Хэлэлцвэл хэлэлцье

Хэлтэрчихээс чинь айна би...” гэсэн нь аман зохиолын ямар төрөл вэ?

- A. Шатрын хожлын үг B. Дом шившлэг C. Дайралцаан
D. Хуримын дуу E. Түргэн хэллэг

38. Д.Равжаагийн “Ичиг, ичиг” шүлгийн орхигдсон хэсгийг нөхөөрэй.

“Аяа бас, номыг үл суранбанди нар ичиг”

- A. өдөржин унтагч B. хэрэн тэнэгч C. цагийг өнгөрөөгч
D. элдвийг сурагч E. гиюүрэн суугч

39. Хүний нүдэнд бол
Хөгцтэй хад шиг
Хөх толгойтой
Хөгшин хүү минь
Ижийнхээ нүдэнд бол
Манцуйдаа тарвалзах
Мяндас цагаан хүү минь. (П.Бадарч)
Шүлгийн тодруулсан мөрд ямар дүрслэх хэрэглүүр илэрсэн бэ?
A. Ёгтлол
B. Төлөөлөл
C. Хүншүүлэл
D. Багасгал
E. Ихэсгэл
40. Ишданзанванжилуун “Гүнгийн зуугийн гэгээний Алтан сургаал”-аас шашин номын ёсыг сахидаггүй, эд хөрөнгөнд шунасан лам хүнийг шүүмжлэн хэлсэн утгатай хэсгийг олно уу.
A. Учирсан нөхөр лүгээ эвтэй журам байвч
Учрыг сонгомжлон тэнцүүлж хяналтай
B. Үсэг эрдэм, суртал үгүй эгэл балай болговол
Үзэл үгүй сохор мэт гагц хүчин зармуй.
C. Шүр, номин, хөх, цагаан зэргэ жинсийг нь үзвэл
Шинжлэлтэй, түвшин мэргэд бат төрийг барилтай
D. Хөвүүнээ суртал үгүй, элмэг эр болговол
Хүнд үндсийг бузарлаж, төрийн ёсонд харшмой.
E. Ариун буян, амьтны сүсэг цагаан хишгийг
Алт мөнгө, шүр номин, будаг хивс болгогч

ХОЁРДУГААР ХЭСЭГ (Харгалзуулах даалгавар)

Санамж:

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг бөглөөрэй.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.

2.1 Хэлцийгойролцоо утгаарньзөвхаргалзуулаарай.

- | | |
|--|--------------------------|
| a. Үхэр хэдгэнийг дээсээр барих | 1. Насны нар хэлбийх |
| b. Өөрөө хожгор байж бусдын халзанг гайхна | 2. Хөхөөг хүйдсээр цохих |
| c. Өрөөлтэй морь гүйцэхээ болих | 3. Нойрыг нь нохой авах |
| d. Сүүнд халсан хүн тараг үлээх | 4. Өндөгнөөс шөрмөс эрэх |
| e. Үнэгний нүдзалгих | 5. Ичсэн хүн, хүн ална |

2.2 Зохиолын өгүүлэгдэхүүний бүрдэл хэсгүүдийн тодорхойлолтыг зөв хариутай нь харгалзуулаарай.

- | | |
|-------------|---|
| a. Төгсгөл | 1. Зохиолын эхлэл хэсгийг залган хөгжүүлж, улмаар зөрчил үүсгэн, үйл явдлын цаашдын өрнөх шалтгаан болж буй хэсэг |
| b. Эхлэл | 2. Зохиолын үйл явдал, зөрчил тэмцэл алгуур хөгжсөөр цаашид үргэлжлэх аргагүй болтлоо хурцдаж, дээд цэгтээ хүрсэн хэсэг |
| c. Зангилаа | 3. Өгүүлэгдэхүүний өрнөх дэвсгэр суурь бөгөөд цаашид зохиолын зөрчил, тэмцэл гарах ахуй амьдрал, нийгмийн нөхцөл, гол баатруудын тухай танилцуулдаг хэсэг |
| d. Туйл | 4. Зохиолчийн өөрийн үнэлэмж, хандлага, дүгнэлт бүхий хэсэг |
| e. Өрнөл | 5. Зангилаа бий болсноос хойш тэрхүү эгзэгтэй зангилааны учир зүйг олохын тулд чөлөөтэй өрнөж буй хэсэг |

2.3 Үгийг тайлбартай нь зөв харгалзуулаарай.

- | | |
|-------------------|---|
| a. бургинаа цас | 1. том том ширхэгтэй цас ихээр малгайлан орох |
| b. шамарга цас | 2. хайлж хөлдсөн цас |
| c. нойтон цас | 3. бага ширхэгтэй цас |
| d. малгайлсан цас | 4. шуургалан орсон нойтон цас |
| e. цас мөс | 5. чийглэг цас |

2.4 Зөвийг нь олж харгалзуулаарай.

		1	2	3	4	5
a	Бүрмөсөн үйлдэх байдлын “-чих” дагавартай үгийг буруу бичсэн үг	олчихоор	авлачихыг	татчхаад	авчихаар	өгчхөөсэй
b	“ийн”г ⁰ ⁰ ⁰ ⁰ бичих үг	ялгал	ñî ðèë	зохиол	учрал	булаг
c	Түр үйлдэх байдлын “- зна ⁴ ” дагаврыг шууд залган бичих үг	оч	унш	өг	бод	шийд
d	Гийгүүлэгчээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад эцсийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшгийг гээхгүй бичих үг	улам+аар	нутаг+аар	Баатар+ыг	журам+ын	бичиг+ээс
e	Зөөлрүүлэх үүргээр орсон “Ь”-тэй үг	чимье	үзье	дохье	бэлдые	гөвье